Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Дуут сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч, засаг дарга С.Ганзориг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн түгээмэл тархацтай ашигт малтмалын орлого бүрдүүлэлт, Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 23-наас 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нарантуул гүйцэтгэв.

Дуут сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/72 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дуут сумын засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай, ил тод нээлттэй, чанартай, тэгш хүргэж ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдийн эрүүл мэндийн байдлыг хамгаалах, залуу малчдыг малжуулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлэх, байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлэх

- Төрийн үйлчилгээг сумынхаа ард иргэдэд ил тод шуурхай хүргэх, амьдрах орчныг сайжруулах, аж амьдралыг дээшлүүлэх, мал аж ахуйг эрчимжүүлэх, залуу малчдыг малжуулах гэсэн олон талт үйл ажиллагаа явуулах

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дуут сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүү, дотоод аудитын албанаас 2020 онд Дуут сумын ТТЗахирагч болон төсөвт байгууллагын 2016-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна.

Дуут сумын ТТЗ-ын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшнийг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Энэ нь материаллаг байдлыг үнэ цэнэ талаас нь авч үзэхийн тулд санхүүгийн тайлангийн хамгийн чухал хэсгүүд болох нийт орлогыг /өөрийн орлого, төсвийн санхүүжилт, татвар болон татварын бус орлого / сонгон авч үзлээ.

Төлөвлөлтийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаас тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нийт орлого 4604892.6 мянган төгрөгөөр 1 хувиар тооцож 46048.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 54010.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 87607.3 мянган төгрөг болж, 33596.6 мянган төгрөгөөр өсөж, төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 33596.6 мянган төгрөг байршиж байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл		/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь	
ОНХС	13,480.0	13,294.4	(185.6)		1.0
СХС	31,773.5	35,980.7	4,207.2		13.2
Төрийн сан	8,757.2	38,332.2	29,575.0		437.7
Дүн	54,010.7	87,607.3	33,596.6		451.9

Эх сурвалж: Дуут сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.2 Авлага

Авлага хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 190245.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл

195163.5 мянган төгрөг болж, 4917.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл		/мянган төгрөг/	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	4,330.0	3,280.0	(1,050.0)
Байгууллагаас авах авлага	7,347.5	13,847.5	6,500.0
Хувь хүмүүсээс авах авлага	1,976.4	2,701.0	724.6
Зээлийн хүүгийн авлага	161,745.8	165,356.6	3,610.8
Төлбөртэй үйлчилгээний авлага	14,846.1	9,978.4	(4,867.7)
Дүн	190,245.8	195,163.5	4,917.7

Эх сурвалж: Дуут сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 165356.6 мянган төгрөгийн СХС, авлага байна.

Нийт авлагын дийлэнхийг сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 161745.8 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 14 иргэнд 45000.0 мянган төгрөгийн зээл олгож, 49207.1 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, оны эцэст 165356.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Сум хөгжүүлэх сангаас 2011-2018 онуудад олгосон 41 зээлдэгчтэй холбогдох 93374.8 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага байгаа нь сангийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн боловч үр дүн төдийлөн гараагүй байна.

Хүснэгт №3. Урьдчилгаа дансны үлдэгдэл		/мянган төгрөг/	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын сан /малжуулах/	32,817.7	26,567.7	(6,250.0)
Дүн	32,817.7	26,567.7	

Эх сурвалж: Дуут сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа данс өмнөх оноос 6250.0 мянган төгрөгөөр буурсан нь оны эцэст 26567.7 мянган төгрөгийн авлага нь малжуулах төсөл хөтөлбөртэй холбоотой, хууль хяналтын байгууллагад шилжүүлэн зээлдэгчид нь хүлээн зөвшөөрсөн барагдуулах боломжтой авлага байна.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 81630.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 66853.9 мянган төгрөг болж, 14776.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл		/мянган төгрөг/	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эм боох материал	1,424.9	7,149.0	5,724.1
Бичиг хэргийн материал	600.4	118.4	(482.0)
Аж ахуйн материал	21,733.4	17,331.7	(4,401.7)
Сэлбэг хэрэгсэл	60.0		(60.0)
Түлш, шатах тослох материал	13,561.4		(13,561.4)
Хүнсний материал	10,442.1	13,514.4	3,072.3
Бусад хангамжийн материал	33,808.1	28,740.4	(5,067.7)
Дүн	81,630.3	66,853.9	(14,776.4)

Эх сурвалж: Дуут сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Эм боох материалын үлдэгдэл 5724.1 мянган төгрөгөөр өссөн, тайланд онд 16545.2 мянган төгрөгөөр хандив, үнэ төлбөргүйгээр бараа материал нэмэгдэж 188049.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4811495.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 6850038.1 мянган төгрөг болж, 2038542.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	3,573,518.7	4,686,958.9	1,113,440.2
Тээврийн хэрэгсэл	254,326.9	254,326.9	-
Машин тоног төхөөрөмж	408,246.8	495,692.9	87,446.1
Тавилга эд хогшил	216,527.2	242,449.0	25,921.8
Түүх соёлын дурсгалт зүйл	947.8	947.8	-
Зам гүүрийн байгууламж		802,370.0	802,370.0
Номын фонд	26,234.0	27,598.8	1,364.8
Бусад үндсэн хөрөнгө	230,952.3	238,952.3	8,000.0
Программ хангамж	6,123.5	6,123.5	-
Бусад биет бус хөрөнгө	94,618.0	94,618.0	-
Дүн	4,811,495.2	6,850,038.1	2,038,542.9

Эх сурвалж: Дуут сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвөөс 7154.0 мянган төгрөгийн бэлтгэсэн, үнэ төлбөргүй хандиваар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2047790.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, 16402.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 8021.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 11207.0 мянган төгрөг болж, 3185.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн				
Ажилчидтай холбогдсон өглөг	1184.8		-1184.8	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	3141.7		-3141.7	-
Байгууллагад төлөх өглөг	3695.2	3565	-130.2	96.5
Татаас санхүүжилтийн өглөг		7642	7642.0	
Нийт дүн	8021.7	11207.0	3185.3	

Эх сурвалж: Дуут сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд байгаа 11207.0 мянган төгрөгийн өр төлбөрийн барагдах боломжтой байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4176244.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 6026933.1 мянган төгрөг болж, 1850688.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, Бууралт -/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,148,593.3	2,148,593.3	-
Хуримтлагдсан үр дүн	1,201,119.5	3,051,808.0	1,850,688.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	826,531.8	826,531.8	-
Дүн	4,176,244.6	6,026,933.1	1,850,688.5

Эх сурвалж: Дуут сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй, тайлант онд 1850688.5 мянган төгрөгийн ашигтай ажиллаж, бодлогын өөрчлөлт алдааны залруулга хийгдээгүй байна.

3.5.10 Орлогын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үнэ төлбөргүй орлого 695058.2, тусгай шилжүүлгийн санхүүжилт 209128.0, аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 75326.7, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого 5321.2, орон нутгаас олгох санхүүжилт 92142.1, мянган төгрөгөөр өссөн, татварын орлого 3618.3, татварын бус орлого 124.0, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 9705.9, нэмэлт санхүүжилтийн орлого 9331.0, ЭМДСангаас 468.0, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих орлого 29311.9 мянган төгрөгөөр тус тус буурчээ.

Хүснэгт № 8 Нийт орлогын гүйцэтгэл		/мянган төгрөг/	
Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,580,475.5	4,604,892.6	1,024,417.1
Татварын орлого	47,010.1	43,391.8	(3,618.3)
Татварын бус орлого	991.6	867.6	(124.0)
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,370,083.3	2,065,141.5	695,058.2
Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого	14,074.7	4,368.8	(9,705.9)
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,027,900.1	1,237,028.1	209,128.0
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	421,090.4	513,232.5	92,142.1
Нэмэлт санхүүжилтийн орлого	97,856.6	88,525.6	(9,331.0)
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	105,553.3	76,241.4	(29,311.9)
Орон нутгийн төсөвт байгууллага төвлөрүүлэх шилжүүлэг	5,104.3	10,425.5	5,321.2
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	470,657.7	545,984.4	75,326.7
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,153.4	19,685.4	(468.0)

3.5.11 Зардлын данс

Нийт зардал өмнөх оноос 461148.9 мянган төгрөгөөр буюу 20.1 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, хөрөнгийн зардал, урсгал шилжүүлгийн зардлууд тус тус өссөн, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, томилолтын зардлууд буурсан байна.

Хүснэгт № 9 . Зарлагын гүйцэтгэл		/мянган төгрөг/		
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
	2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,367,632.3	2,754,204.1	386,571.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,065,428.8	1,230,834.7	165,405.9
2102	Ажил олгогчоос даатгалд төлөх	121,092.7	150,861.7	29,769.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,517.7	113,548.3	8,030.6
2104	Хангамж, бараа материалын зардал	150,445.0	67,543.9	(82,901.1)
2105	Нормативт зардал	107,027.8	59,213.5	(47,814.3)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,975.6	65,803.3	45,827.7
2107	Томилолт, зочны зардал	82,863.4	2,313.7	(80,549.7)

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	35,266.3	42,317.7	7,051.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	196,497.3	255,675.1	59,177.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	483,517.7	691,576.2	208,058.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		74,516.0	74,516.0

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Дуут сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 9/02 тоот тогтоолд Дуут сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 27737.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 44259.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 159.6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 10.. Сумын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Орлогын ангилал	2020 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
	27,737.0	44,259.4	(16,522.4)
Нийт орлого ба тусламжийн дүн	27,737.0	44,259.4	(16,522.4)
Татварын орлого	26,737.0	43,391.8	(16,654.8)
Орлогын албан татвар	7,025.0	20,720.0	(13,695.0)
Хувь хиний орлогын албан татвар	7,025.0	20,720.0	(13,695.0)
Йл ажиллагааны орлого	200.0	1,867.7	(1,667.7)
Шууд бус орлого	6,825.0	18,852.3	(12,027.3)
Хөрөнгийн албан татвар	17,108.0	17,078.7	29.3
Бууны албан татвар	3,608.0	2,742.0	866.0
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	13,500.0	14,336.7	(836.7)
Бусад татвар, төлбөр, хураамж	2,604.0	5,593.1	(2,989.1)
Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,890.0	4,080.5	(2,190.5)
Улсын тэмдэгтийн хураамж	980.0	914.6	65.4
Тигээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	200.0	2,048.9	(1,848.9)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	710.0	1,117.0	(407.0)
Газрын төлбөр	-	106.5	(106.5)
Байгалийн нөөц ашигласны төлбөр	714.0	1,406.1	(692.1)
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	214.0	887.0	(673.0)
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	714.0	1,406.1	(692.1)
Татварын бус орлого	1,000.0	867.6	132.4
Нийтлэг татварын бус орлого	1,000.0	867.6	132.4
Торгуулийн орлого	1,000.0	867.6	132.4

Эх сурвалж: Дуут сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн төлөвлөлт

ХОА-2021/5 /СТА-ТТЗ

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2724193.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2724193.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 119509.1 мянган төгрөгөөр бууруулж 2604684.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 1940426.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1813144.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 45000.0 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн зардалд, 82281.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1237028.1 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих, 622403.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 60185.0 төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлого, 20810.0 мянган төгрөгийг ЭМД-ийн сангаас, 13480.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр тусгай шилжүүлгээс 1125760.2, орон нутгаас 611800.3, ЭМДС-аас 19685.4, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 1318.5, туслах үйл ажиллагааны орлого 54020.2 мянган төгрөг нийт 1812584.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орон нутгийн төсөвт 18067.5, аймгийн төсөвт 111267.9 бүгд 129335.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №.11. Санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Нийт төлөвлөгөө			Гүйцэтгэл			Зөрүү	Тайлбар
		Санхүүжилт	Өөрийн орлого	нийт	Санхүүжилт	өөрийн орлого	Нийт		
1	ЗДТГ	344,605.0	605.0	345,210.0	340,074.2	605.0	340,679.2	(4,530.8)	татан төвлөрүүлсэн
2	ИТХ	51,919.6		51,919.6	50,808.7		50,808.7	(1,110.9)	татан төвлөрүүлсэн
3	Сум хөгжүүлэх сан		45,000.0	45,000.0		49,207.2	49,207.2	4,207.2	зээл, зээлийн хүүгийн орлого
4	ОНХС	82,281.4		82,281.4	68,801.4	4,713.0	73,514.4	(8,767.0)	
	ОНБ-дын дүн	478,806.0	45,605.0	524,411.0	459,684.3	54,525.2	514,209.5	(10,201.5)	
5	ЕБСургууль	714,172.7	100.0	714,272.7	616,627.8	100.0	616,727.8	(97,544.9)	татан төвлөрүүлсэн
6	Хүүхдийн цэцэрлэг	229,523.5		229,523.5	217,798.2		217,798.2	(11,725.3)	татан төвлөрүүлсэн
7	ЭМТөв	377,657.0		377,657.0	373,567.7		373,567.7	(4,089.3)	ЭМД-ын сангаас авах санхүүжилтээ бүрэн аваагүй
8	Соёлын төв	93,562.0	1,000.0	94,562.0	89,567.9	713.5	90,281.4	(4,280.6)	өөрийн орлого тасарсан
	ТЗШ дүн	1,414,915.2	1,100.0	1,416,015.2	1,297,561.6	813.5	1,298,375.1	(117,640.1)	
	Нийт дүн	1,893,721.2	46,705.0	1,940,426.2	1,757,245.9	55,338.7	1,812,584.6	(127,841.6)	

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 55338.7 мянган төгрөгөөр бүрдүүлж, батлагдсан 4813.1 мянган төгрөгөөр илүү бүрдүүлсэн нь өмнөх оны малжуулах хөтөлбөрийн авлагаас, Соёлын төвийн үндсэн үйл ажиллагааны орлого 286.5 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 15 төсөл, арга хэмжээнд 82281.4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 73700.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 13294.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1808563.0 мянган төгрөг нь 93.2 хувьтай байгаа нь ЕБСургууль, Цэцэрлэг, ЭМТөв болон бусад төсөвт байгууллагууд аймгийн болон сумын орон нутгийн төсөвт хэмнэгдсэн төсвийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Онцгой байдлаас Ковид-19 цар тахлын зардал, статистикийн судалгааны зардал, Онцгой байдлаас гамшгийн зардал, аймгийн ОНХС-аас байгууллагуудын засварын зардал, судалгааны зардал, ЭМГ-аас эм бэлдмэлийн санхүүжилт болон сорьц тээврийн зардлуудыг нэмэлт орлогын дансанд 8819.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Хүснэгт №12 Нэмэлт данс
/мянган төгрөг/

Бусад орлого		Нийт		
1	ЗДТГ	81,745.6	81,745.6	Аймгийн ОНХСангаас ЗДТГазар, ЭМТөвийн засварын зардал, Статистикаас судалгааны зардал
3	ЕБСургууль	1,094.0	1,094.0	Сурах бичгийн түрээсийн орлого
5	ЭМТ	5,979.6	5,979.6	ЭМГ -аас эм бэлдмэлийн үнийн санхүүжилт, сорьц тээврийн зардал
Нийт дүн		88,819.2	88,819.2	

Үүнээс үндсэн цалин, шимтгэлд, хангамж бараа материалын зардал, эм эмнэлгийн хэрэгсэл авах зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, бусад бараа үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 138 мэдээллээс 127 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож, оруулах хугацаа болоогүй 2 мэдээлэл, санхүүгийн тайлан болон аудитын тайлан, дүгнэлтийн PDF -ээр оруулахдаа алдаатай байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид албан шаардлага өгөгдөөгүй, 1 алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт 75 хувьтай хэрэгжсэн байна.

Хүснэгт 13. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	1		1		-	-	75
Нийт	1	-	1	-	-	-	75

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 3 тайланг түүвэрт хамруулсан байна.

Хүснэгт №14. Аудитад хамрагдсан хэлбэр, аудитын дүгнэлт

№	Байгууллагын ангилал, нэр	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр			Аудитын дүгнэлт	
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Гэрээгээр хийлгэсэн	Зөрчилгүй	хязгаарлалттай
1	ЗДТГ	1			1	

2		ИТХ		1		
3	Төсвийн шууд захирагч	Сургууль	1		1	
4		Цэцэрлэг	1		1	
5		Соёлын төв	1		1	1
6		ЭМТөв	1		1	
7	ОНТС	СХС		1		
8		ОНХС		1		
Дүн			5	3	1	4

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-4, “Хязгаарлалттай” 1, нийт 5 дүгнэлт гаргасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчил:

Аудитаар нийт 57136.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5136.0 мянган төгрөгийн алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- ЭМТ-ийн 2020 онд зарцуулсан тендерийн эмийн үнэ 5136.0 мянган төгрөгийг ЭМГ-аас төлсөн, ТТЗ-ийн тайланд үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй орхигдуулсныг залруулсан болно.

Хүснэгт № 15. ТТЗ-ийн тайланд илэрсэн алдаа / мянган төгрөг/

№	Байгууллагын ангилал, нэр	нийт илэрсэн алдаа				Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
		нийт илэрсэн алдаа		Үүнээс залруулсан		Залруулаагүй		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	ТТЗ	3	6,136.0	1	5,136.0	2	1,000.0					2	1,000.0
2	ОНТС	СХС	-	-									
3		ОНХС	1	51,000.0			1	51,000.0			1	51,000.0	
		ИТХ	-	-									
Дүн		4	57,136.0	1	5,136.0	3	52,000.0	-	-	1	51,000	2	1,000.0

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Аудитаар 52000.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 51000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага шилжүүлээ. Үүнд:

1. Тайлант онд ОНХС-аар хийгдэх 15 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар ажил гүйцэтгүүлэхдээ гүйцэтгэл, явцын мэдээ, олгосон төсвийн гүйцэтгэлийг хянадаггүй, урьдчилгаа санхүүжилтийг өндөр дүнгээр олгодог, дотоод хяналт хэрэгжүүлээгүй, иргэдийн төлөөлөгчдийг чадавхжуулах хөтөлбөр зардлаас бурхан залах, мод тарих зэрэгт зориулалт бусаар зарцуулсан, хог цэвэрлэх хөтөлбөрийн зардлаас НИК ХХК-тай гэрээ байгуулж, шатахуун олгох зөвшөөрлийн бичгээр ЗДТГазрын дарга нь олгосон тамгын газрын үйл ажиллагааны зардлыг давхардуулан гаргасан эсэхийг хянах боломжгүй,

гамшгаас хамгаалах хөтөлбөрийн зардлаас эд хариуцагчтай гэрээ байгуулж харилцах данс руу төлбөрийг шилжүүлж маск, ариутгалын зүйл худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 4 зүйлийн 4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөрийг үүсгэхгүй байх", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" 8 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 60 дугаар зүйлийн 60.3.6-д "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны 228 дугаар журмын 3.1.2-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;" 3.1.4-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах", 3.11.3-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх", 4.2-д "ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно", гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

Төвлөрүүлсэн захирагчид 1000.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 2 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн алдаа, зөрчил

Дуут сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 84869.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 1094.0 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 83775.5 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 1474.6 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд төлбөрийн акт, 6673.6 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд албан шаардлага, 75627.3 мянган төгрөгийн 11 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 16. ТТЗ-ын нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил, шийдвэрлэлт /мянган.төгрөг/

№	Байгууллагын ангилал, нэр	нийт илэрсэн алдаа		Үүнээс залруулсан		Залруулаагүй	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	ЗДТГ	3	13,200.0			3	13,200.0
2	ИТХ	-	-				
3	Сургууль	3	9,443.2	1	1,094.0	2	8,349.2
4	Цэцэрлэг	4	5,338.8			4	5,338.8
5	Соёлын төв	2	6,019.5			2	6,019.5
9	ЭМТөв	3	50,868.0			3	50,868.0
	Дүн	15	84,869.5	1	1,094.0	14	83,775.5

№	Байгууллагын ангилал, нэр	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
		тоо	дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	ЗДТГ	3	13,200.0					3	13,200.00
2	ИТХ	0	-						
3	Сургууль	2	8,349.2					2	8,349.2
4	Цэцэрлэг	4	5,338.8	1	1,474.6			3	3,864.2

5	Соёлын төв	2	6,019.5			2	6,019.5
9	ЭМТөв	3	50,868.0			2	6673.6
	Дүн	14	83,775.5	1	1474.6	2	6673.6
						11	75,627.3

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудалгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1. **Илрүүлэлт:** Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сургуулийн спорт заал, сумын төвийн гэрэлтүүлэг, зам засвар, ЭМТөвийн барилгын засвар хийгдэж түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтыг зураг, төсөв болон холбогдох материалд үндэслэн ногдуулалтыг хийгээгүй, сумын ИТХ-ын тэргүүлэгчид холбогдох тогтоол шийдвэр гаргаагүй, байцаагч нь өөрөө аж ахуйн нэгж байгууллагатай амаар тохирч ногдуулалт хийсэн, сургуулийн спорт заалны нээлтийн үйл ажиллагааны уралдаан тэмцээн зохион байгуулахад хандив хэлбэрээр олгож зарцуулсан зөрчил илэрлээ.

1.2. **Эрсдэл:** Орлого бүрэн бүрдүүлээгүй байх, санхүүгийн тайланд орлого дутуу тусгах,

1.3. **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэсэн заалтыг мөрдөх, сумын ИТХ-аар тогтоол шийдвэр, гаргуулах, зураг төсвийг үндэслэн ногдуулалт хийж ажиллах

1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

2.1 . Шилэн дансны хуульд заасан мэдээлэлтэй холбоотой асуудал

2.1.1. **Илрүүлэлт:** Шилэн данс мэдээллийг хянахад shilendans.gov.mn цахим сайтад санхүүгийн тайлан, аудитын тайлан дүгнэлтийг PDF -ээр байршуулахдаа алдаатай оруулж мэдээллийг харах боломжгүй байна. .

2.1.2. **Эрсдэл:** Мэдээлэл харагдах боломжгүй байх, үнэн байдал алдагдах,

2.1.3 **Өгсөн зөвлөмж:** Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.1.17-д “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор, хагас жилийн тайланг 8 дугаар сарын 15-ны дотор PDF, Excel, XML форматаар,” гэсэн заалтыг мөрдөн мэдээллийг үнэн зөв байршуулах

2.1.4 **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 15-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.
Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Дуут сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	Аудитын код:
--------	--------------	--	--------------

2020

ХОА-2021/05/СТА-ТТЗ

Шалгагдсан
байгууллагын нэр:

Дуут сумын Засаг дарга

Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	ЭМТөв нь тендерийн эмийг үнэ төлбөргүй орлогоо хүлээн зөвшөөрч бүртгээгүй	5136.0	Залруулга хийх	ЭМТ-ийн эрхлэгч эмч, нягтлан бодогч	Б.Түмбаяр Б.Отгонзаяа
2	Төсвийн тухай хууль, ОНХС-ийн журмын холбогдох заалтуудыг зөрчин, ИНХ-аар эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн, анхан шатны баримтууд бүрэн бус	51000.0	Албан шаардлага	Засаг дарга, Санхүүгийн албаны дарга	С.Ганзориг, А.Оюунбилэг
3	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтыг зураг, төсөв болон холбогдох материалд үндэслэн ногдуулалтыг хийгээгүй, сумын ИТХ-ын тэргүүлэгчид холбогдох тогтоол шийдвэр гаргаагүй, байцаагч нь өөрөө аж ахуйн нэгж байгууллагатай амаар тохирч ногдуулалт хийдэг зөрчил илэрлээ	1000.0	Зөвлөмж өгөх	ИТХ-ын дарга, Засаг дарга, Санхүүгийн албаны дарга	С.Ганзориг Ц.Одбаатар А.Оюунбилэг
4	shilendans.gov.mn цахим сайтад санхүүгийн тайлан, аудитын тайлан дүгнэлтийг PDF -ээр оруулахдаа алдаа оруулж байршуулсан		Зөвлөмж өгөх	Засаг дарга, санхүүгийн албаны дарга	С.Ганзориг А.Оюунбилэг
	Дүн	57136.0			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР